



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/342

Чойбалсан

Г Хот байгуулалтын орон тооны бус 7
зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх Хот байгуулалтын орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн нэгдүгээр, зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хот байгуулалтын орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлд тусгаж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (В.Цэнгэлмаа)-т даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор аймгийн Засаг даргын 2017 оны А/240 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ЁЛ

Аймгийн Засаг даргын 2025 оны
0.6. дугаар сарын 10-ны өдрийн
А/3.42 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ОРОН ТООНЫ БҮС
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Зөвлөлийн дарга: -Аймгийн Засаг дарга
- Дэд дарга: -Аймгийн Засаг даргын орлогч
- Нарийн бичгийн дарга: -Аймгийн Ерөнхий архитектор
- Гишүүд:
- Аймгийн Засаг даргын орон тооны бүс зөвлөх
 - Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч
 - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зам тээвэр, эрчим хүч, газрын харилцаа, барилга, хот байгуулалтын бодлогын хорооны дарга
 - Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн Газрын харилцааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн Дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
 - Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга
 - Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга
 - Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга

-Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч

-Аймгийн Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, халдвар, хамгааллын хяналтын улсын байцаагч

-Чойбалсан хотын архитектор

-“ДБЭХС” ТӨХК-ийн Ерөнхий инженер

-“ДБЭХС” ТӨХК-ийн Цахилгаан шугам сүлжээний цехийн дарга


-“ДБЭХС” ТӨХК-ийн Дулааны шугам сүлжээний цехийн дарга

-“Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер

-“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн Дорнод салбарын Ерөнхий инженер

---oOo---

Аймгийн Засаг даргын 06... оны
06... дугаар сарын 12...-ны өдрийн
А/342... дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ХОТ БАЙГУУЛАЛТЫН ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Зорилго: Монгол Улсын Хот байгуулалтын тухай хуулийн хүрээнд иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг хангах, хот суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газар, гэр хорооллын газрыг дахин төлөвлөх, барилгажуулах, газрын харилцааг боловсронгуй болгох, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, инженерийн шугам сүлжээг өргөтгөх, шинээр байгуулах, хот байгуулалтын төлөвлөлтийн оновчтой шийдлийг гаргахад оршино.

1.1. Монгол улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм, үндэсний хөтөлбөр, улс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөө, Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг удирдлага болгон ажиллана.

1.2. Хот байгуулалтын зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/-ийн үйл ажиллагаа нь барилга, хот байгуулалт, түүний дэд бүтэц, газрын харилцааны талаар баримтлах төрийн бодлого, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд салбаруудын үйл ажиллагааг хөгжүүлэх ажлыг уялдуулан зохицуулах тааар зөвлөмж өгөх, хот байгуулалтын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

1.3. Зөвлөл нь орон тооны бус байх ба түүний ажиллах журам, бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын захирамжаар батална.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

Хот байгуулалтын зөвлөл нь үйл ажиллагаандаа энэхүү журам, Монгол Улсын "Газрын тухай", "Хот байгуулалтын тухай", "Хот тосгон эрх зүйн байдлын тухай", "Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай" "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" "Барилгын тухай", "Орон сууцны тухай", "Байгаль орчныг хамгаалах тухай", "Кадастрын зураглал ба кадастрын тухай" багц хуулиуд тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд, норм норматив бусад эрх зүйн актыг удирдлага болгоно.

2.1. Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөв, салбарын стратеги төлөвлөлтийн бодлоготой уялдуулан улс, орон нутгийн төсөв, хандивлагчдын зээл, тусламжийн хөрөнгөөр, түүнчлэн бизнес төлөвлөгөөний дагуу барихаар төлөвлөгдсөн инженерийн хийцтэй барилга, байгууламжийн бүхий л асуудлыг шийдвэрлэж, хүн амын суурьшилт, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үндсэн шийдэлтэй уялдуулан боловсруулсан аймгийн нутаг дэвсгэрийн хөгжлийн төсөл төсөөлөл, хотын ерөнхий төлөвлөгөөг уялдуулан зохицуулах үйл ажиллагааг явуулна.

Гурав.Зөвлөлийн бүрэлдэхүүн

3.1.Зөвлөл нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

3.2.Зөвлөлийн дарга нь аймгийн Засаг дарга байна.

3.3.Зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, гарсан зөвлөмж дүгнэлтийг баталгаажуулах, холбогдох газар байгууллагуудад хүргүүлэх, зөвлөлөөр хэлэлцсэн асуудлын холбогдох материалыг архивын нэгж бүрдүүлэн зохих журмын дагуу архивт шилжүүлэх үүргийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцна.

3.4.Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь аймгийн Ерөнхий архитектор байна.

Дөрөв.Зөвлөлийн эрх

4.1.Холбогдох хууль тогтоомж, хот байгуулалт, барилгажилтын норм стандарт, дүрэм журам, батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг зөрчсөн барилгын зураг төслийг хүлээн авч хэлэлцэхээс татгалзах.

4.2.Монгол Улсын Их хурал, Засгийн газар, салбарын яам, агентлагаас хэрэгжүүлж буй бодлого, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд санал боловсруулан, шаардлагатай тохиолдолд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэр гаргуулан ажиллах.

4.3.Хот байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэх явцад орон нутгийн онцлог, цаг үеийн зайлшгүй шаардлагаас өөрчлөлт, тодотгол оруулахаар бол үндэслэл, судалгааг бүрдүүлж холбогдох байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.

4.4.Хот байгуулалтын бодлогын хүрээнд байгаль орчныг хамгаалах, газар зохион байгуулалт, орчны эрүүл ахуй, аюулгүй байдал, инженерийн шугам сүлжээний эх үүсвэрүүдийн найдвартай ажиллагааны талаар холбогдох тооцоо, судалгаа, мэдээллийг гарган, хот байгуулалтын сөрөг үр дагаврыг хязгаарлах арга хэмжээ авах.

4.5.Зөвлөлийн гишүүдийг гадаад, дотоодод туршлага судлуулах ажлыг зохион байгуулах.

4.6.Хэлэлцэх асуудалд хамааралтай мэргэжлийн байгууллага, албан тушаалтныг оролцуулж, шийдвэр зөвлөмж гарган хамтран ажиллах.

Тав.Зөвлөлийн үүрэг.

5.1.Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шинээр эзэмшүүлж, ашиглуулах, өмчлүүлэх газрын асуудлыг хэлэлцэн дүгнэлт гаргах.

5.2.Барилга байгууламжийн зураг төсөлд санал өгч, нэгдсэн дүгнэлт гаргах.

5.3.Барилга байгууламж шинээр барих, шинэчлэн засварлахтай холбоотойгоор гудамж, зам талбай сэтлэх, шугам сүлжээнд холболт хийх, мод цэцэрлэгийг түр зайлуулах, нөхөн сэргээх, газрыг тохижуулах зэрэг ажлыг оновчтой шийдвэрлэхэд санал өгч, дүгнэлт гаргах.

5.4.Шинээр баригдах барилга байгууламжуудыг тухайн орон нутгийн онцлог, оршин суугчдын зан заншил, үндэсний улдамжлал, орчны барилгажилт, орон зайн харилцаа, зайлшгүй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулсан зураг төслөөр бариулах, орчны тохижилт, зам талбай, реклам чимэглэл, архитектурын жижиг хэлбэрүүдийг иж бүрнээр нь гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах.

5.5.Сумдын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө, түүнд оруулсан өөрчлөлтийг хэлэлцэн дүгнэлт, зөвлөмж гаргах.

5.6.Эзэмшил газрын байршил, зориулалтыг өөрчлөх, талбайн хэмжээг өөрчлөх асуудлыг хэлэлцэн дүгнэлт гаргах.

5.7.Холбогдох хууль тогтоомж зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргах, шийдвэрлэх арга хэмжээний саналыг аймгийн Засаг даргад дэвшүүлэх.

5.8.Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр гарган, аймгийн Засаг даргад тайлагнах.

Зургаа.Хуралдааны бэлтгэлийг хангах

6.1.Хуралдааны бэлтгэл хангах үүргийг Зөвлөлийн даргын өмнө зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцна.

6.2.Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх материал, баримт бичгийн эхийг нэг хувь, танилцуулга, бусад материалыг гишүүдийн тоогоор хувиалан бэлтгэж, зөвлөлийн хуралдаан хуралдахаас 7 хоногийн өмнө зөвлөлийн нарийн бичгийн даргад бичгээр болон цахим файл хэлбэрээр ирүүлсэн байна.

6.3.Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх материал, баримт бичгийг танилцуулга хэлбэрээр бэлтгэн, асуудлыг хэлэлцүүлэх болсон үндэслэл, шаардлага, үүсэж болох үр дагаврууд, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, ач холбогдол, үр дүнг оновчтой тодорхойлсон байна.

6.4.Нарийн бичгийн дарга зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх материал, баримт бичгийг зөвлөлийн даргад танилцуулах ба түүний зөвшөөрлийг үндэслэн хэлэлцэх асуудлын дараалалд оруулж, гишүүдэд 3-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ.

Долоо.Зөвлөлийн үйл ажиллагаа, хуралдааны зохион байгуулалт

7.1.Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, бүх шатны зураг төслийн хэрэгжилтийг хянах, зохион байгуулах, техникийн нөхцөл олгох, барилгажилт, архитектур, тохижилт, орон зайн зохиомж, дэд бүтэц, гудамж замын сүлжээ, орчны бүсийн төлөвлөлтийн асуудлыг уялдуулан зохицуулж, аймгийн Засаг даргыг мэргэжил арга зүйгээр хангана.

7.2.Зөвлөл нь сар бүрийн 2 дугаар долоо хоногийн 2 дахь өдрийн 14:00 цагт, шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг Зөвлөлийн дарга зарлан хуралдуулж, хуралдаанаас дүгнэлт, зөвлөмж гаргана.

7.3.Зөвлөлийн хуралдааныг зөвлөлийн дарга удирдах ба хэлэлцэх асуудлын талаар танилцуулгыг зөвлөлийн нарийн бичгийн дарга тахилцуулна.

7.4.Зөвлөлийн даргын эзгүйд түүний эрх олгосноор Дэд дарга хуралдааныг удирдах ба ажлын үр дүнг хариуцна.

7.5.Зөвлөлийн нарийн бичгийн дарга гишүүдийн ирцийг бүртгэж, хуралдааны тэмдэглэлийг хөтлөн Зөвлөлийн даргад танилцуулж баталгаажуулах, хуралдаанаас гарсан шийдвэрийг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэх, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүргийг хүлээнэ.

7.6.Зөвлөлийн хуралдаанд нийт гишүүдийн олонхи оролцсон тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.

7.7.Зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцож чадахгүй тохиолдолд 2-оос доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

7.8.Хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцож чадахгүй тохиолдолд хэлэлцэх асуудлын хүрээнд өөрийн саналыг бичгээр гаргаж нарийн бичгийн даргад урьдчилан ирүүлсэн байна. Энэ тохиолдолд хурлын ирцэд оруулан тооцож болно.

7.9.Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, гишүүдийн дэмжлэг аваагүй асуудлын үндэслэл тайлбарыг тодорхой бичиж, холбогдох баримт материалын хамт буцаана.

---oOo---